

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.ЦОГТГЭРЭЛ

2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр

**ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ 16 дугаар зүйлийн 17 дох хэсэгт “төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж;

Түүнчлэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт мэдээллийг нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчмыг удирдлага болгоно гэж;

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн² 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй.”, мөн зүйлийн 7.7 дахь хэсэгт “Нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.” гэж;

Монгол Улсын Их Хурал (“УИХ”)-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын Мэдээллийн нууцлал хэсгийн 3.6.3.2-д “Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.” гэж;

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 5.4-т “иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ”, 7.5-д “төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн,

¹ 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Монгол Улсын Үндсэн хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

² 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно” гэж;

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Авлигагүй засаглалын зорилт 5.6-гийн 5.6.3-т “Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно”, 5.6.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна” гэж;

УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4 Ил тод байдал, хяналт хэсгийн 4.1.4.1-д “Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.” гэж тус тус заасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн шаардлага болж байна.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг тодорхойлохдоо тус зүйлийн 17 дох хэсэгт “төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж зааснаар хүний мэдээлэл хайх, хүлээн авах, ашиглах эрхийг гагцхүү хууль батлах замаар хязгаарлах, аливаа нууцыг хуулиар тогтоох, хамгаалах эрх зүйн үндсийг тодорхойлжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд ийнхүү заасны дагуу УИХ 1995 онд Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиудыг баталж, төрийн нууцыг тогтоох, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцааг анх хуульчлан зохицуулсан. Эдгээр хуулиудад тухай бүр нэмэлт, өөрчлөлт орж, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг 2004 онд шинэчлэн баталсан. Харин УИХ 2016 оны 12 дугаар сарын 01-нд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс тус хууль хэрэгжсэнээр Төрийн нууцын тухай хууль болон Төрийн нууцын жагсаалт батлах хууль тус тус хүчингүй болсон билээ.

УИХ дараах хүрээнд хамаарах мэдээллүүдийг төрийн нууцад хамруулахаар хуульчилсан байна. Үүнд:

№	Өмнө (Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль)	Уг хүрээнд хамаарах мэдээллийн төрөл (тоо)	Одоо (Төрийн болон албаны нууцын тухай хууль)	Уг хүрээнд хамаарах мэдээллийн төрөл (тоо)
1	Монгол Улсын үндэсний аюулгүй байдал	19	Төрийн бодлого	9

2	Батлан хамгаалах	14	Батлан хамгаалах	16
3	Эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи	5	Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи	4
4	Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил	15	Тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажил	18
5	Бусад	7	Мэдээллийн аюулгүй байдал болон бусад	14
Нийт		60		61

Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдахаас өмнө зөвхөн УИХ дээрх хүснэгт дэх 60 төрлийн мэдээллийг задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээлэл гэж үзэн төрийн нууцад хамааруулж байсан ба хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулахыг хориглодог, мөн тус байгууллагын шийдвээр төрийн нууцыг ил болгодог байсан.

Тэгвэл Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдсанаар төрийн нууцад хамаарах хүрээний мэдээллийн жагсаалтыг уг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт оруулан хуульчилж, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн дагуу төрийн байгууллага болон хуулийн этгээд нь салбар, байгууллагын хэмжээнд нууцлах шаардлагатай төрийн нууцад хамаарах мэдээллийг 13.1 дэх хэсэгт заасан жагсаалтын хүрээнд боловсруулж, тагнуулын байгууллагын санал авч, Засгийн газраар батлуулах зохицуулалт Монгол Улсад шинээр хэрэгжиж эхэлсэн юм. Ингэснээр өмнө нь зөвхөн УИХ хууль батлан тогтоож байсан төрийн нууцын жагсаалтыг Засгийн газар дэлгэрүүлэн батлах эрхтэй болсон. Үүнээс гадна Засгийн газар мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах, төрийн болон албаны нууцыг харилцан солилцох, хамгаалах тухай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах, төрийн болон албаны нууцтай холбоотой журам, заавар батлах зэрэг эрхтэй болжээ.

Шинэ хууль хэрэгжсэнээр Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоол³, түүний хавсралтаар⁴ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан жагсаалттай давхардсан тоогоор 14 салбарын 290 орчим мэдээлэл, 21 байгууллагад хамаарах 330 орчим мэдээлэл, нийт 620 орчим мэдээллийг төрийн нууцад хамааруулж, тэдгээрийн нууцын зэрэглэл, нууцлах хугацааг тогтоосон байна. Уг тогтоолд 2019 оноос хойш 2024 оны зургаан жилийн хугацаанд нийт найман тогтоолоор, жил бүр нэгээс хоёр удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Холбогдох судалгааны тайлангуудад тус жагсаалтад хуульд заагаагүй буюу хуульд заасан төрийн нууцад хамаарахгүй мэдээллүүд багтсан, хоорондоо логик уялдаа холбоогүйн улмаас төрийн нууцын тухай ойлголт тодорхой бус болсон, зарим мэдээлэл нь үндэсний аюулгүй байдалд хамааралгүй байгааг дурдсан байна. Тухайлбал УИХ, түүний Тамгын газрын мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, мэдээллийг төрийн нууцад авсан. Төрийн нууцад хамруулах мэдээллийн жагсаалтыг Засгийн газар нь баталдаг орнуудад олон

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12878>

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208019&showType=1>

нийтийн мэдэх эрх зөрчигдөх магадлал нэмэгддэгийг ч судалгааны тайланд дурджээ.⁵

Монгол Улсын Засгийн газар нууцын жагсаалт батлах, мэдээллийг нууцлах, ил болгох зэрэг эрхтэй болсноос гадна Төрийн болон албаны нууцын тухай хуульд албаны нууц гэх ойлголт, зохицуулалт шинээр туссан. Хуульд "албаны нууц" гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно⁶ гэж тодорхойлохдоо "салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол" гэх өргөн хүрээний ойлголтыг аливаа шалгуур үзүүлэлтгүйгээр, хэт ерөнхийлөн хамруулсан байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт "Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.", мөн зүйлийн 14.2 дахь хэсэгт "Энэ зүйлийн 14.1-д заасан жагсаалтыг батлахад тагнуулын байгууллагын саналыг авна." гэжээ. Тэгвэл тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт "Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь энэ хуулийн 13.2, 14.1-д заасан жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авч, нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналаа нэн даруй удирдлагадаа танилцуулна.", мөн зүйлийн 15.5 дахь хэсэгт уг саналыг хүлээн авсан албан тушаалтан тухайн мэдээлэлд шинжилгээ хийж, жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл нууцлахаас татгалзах эсэхийг Засгийн газрын баталсан журмын дагуу шийдвэрлэнэ хэмээжээ. Уг журам нь Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам⁷ бөгөөд энэ журмаар тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан мэдээллийг нууцад авах шийдвэр гаргах боломжтой болсон нь Монгол Улсны Үндсэн хуульд нууцыг хуулиар тогтоон хамгаална гэсэн суурь зарчимд нийцэхгүй байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар нээлттэй байх ёстой мэдээллийг төрийн байгууллагын албаны нууцад хамруулах болон хувь хүний нууц, хувийн мэдээллийг албаны нууц гэх ойлголтод хамруулах асуудал цөөнгүй байгааг судалгааны тайланд дурджээ. Жишээлбэл, Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын А/112 тоот "Журам, жагсаалт батлах тухай" захирамжийн хоёрдугаар хавсралтад хувь хүний нууц мэдээллийг албаны нууцад тооцож, 10 жил нууцлахаар тусгасан байна⁸.

Дээр дурдсанчлан манай улсын Үндсэн хуульд зааснаар мэдээллийг нууцлахдаа гагцхүү хуулиар тогтоох замаар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах, ашиглах эрхийг хязгаарлах бөгөөд ардчилсан улсад төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх ёстой.

⁵ -Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт: Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага, Нийтийн эрх зүй болон хувийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть – 293, 322 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2024 он

- Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Нийтийн эрх зүй болон хувийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть – 147-148 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2024 он

⁶ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт

⁷ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208025&showType=1>

⁸ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Нийтийн эрх зүй болон хувийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть – 148 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2024 он

Гэвч өмнө харьцангуй тогтвортой, тодорхой байсан харилцаа өнөөдөр маш их хөдөлгөөнтэй, нууц тогтоох асуудал өргөн хүрээг хамарсан, мэдээллийг хаалттай, хүртээмжгүй болгож байгаа нь олон нийт, татвар төлөгчдийн мэдэх эрхийг зөрчиж, төрийн үйл ажиллагааг хүнд сурталтай, хаалттай, зардалтай болгох, авлига, албан тушаалын гэмт хэргийн тоо өсөх хүчин зүйлсийн нэг болж буй юм.

Монгол Улс сүүлийн жилүүдэд авлигын индекс, ардчиллын индекс, хэвлэлийн эрх чөлөөний индексээр тогтмол ухарч буй бөгөөд хамгийн сүүлд 2025 оны хуулийн засаглалын олон улсын индекс зарлахад нийлбэр дүнгээр 142 орноос 67 дугаарт эрэмбэлэгджээ.

Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд уг хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана:

- Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар баталж, төрийн нууц тогтоох, ил болгох эрхийг гагцхүү УИХ-д хадгалуулна;

- хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулахыг хориглоно;

- i) УИХ-аас хуульчлан тогтоосон төрийн нууцын жагсаалтад хамаарах 61 мэдээллийг салбарын болон байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууц гэж Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад авах, ii) задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах мэдээлэл гэх хэт ерөнхий, шалгуур үзүүлэлт тодорхой бусаар мэдээллийг албаны нууцад авах зохицуулалтыг хуулиас хассанаар иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөө, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх нөхцөл боломжийг хязгаарлаж буйг өөрчилнө.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараах үр дагавар гарна гэж үзэж байна:

- Хуулийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллээс бусад төрийн нууцад авах шаардлагагүй мэдээллийг нууцлахыг хязгаарласнаар мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдал нэмэгдэж, төрийн үйл ажиллагаан дахь олон нийтийн хяналт сайжирч, иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг хангана;

- авлига, албан тушаалын гэмт хэрэг буурна;

- төрийн нууцад үл хамаарах мэдээллийг нууцалснаас, төрийн нууцын хүрээг хэт өргөтгөж, өөрчилж буйгаас үүдэх нууц мэдээлэл хадгалах, хамгаалах, ашиглахтай холбоотой аливаа үйл ажиллагаанд шаардагдах цаг хугацаа, зардал, хүнд суртал зэрэг буурна;

- төрийн нууцад үл хамаарах мэдээллийг нууцалсантай холбоотой хуулийн хариуцлагад аливаа этгээд холбогдох, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, хязгаарлагдах гэх мэт сөрөг үр дагавар, эрсдэл буурна.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Тус хуулийн төсөлтэй уялдуулан Төрийн болон албаны нууцын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсрууллаа.

-----oOo-----